



58 Page



59 Page



60 Page



61 Page

Иаков1

-Jacob1-

Тайлбарлагч Исаак Ребека хоёрын дундаас ихэр хүү мэндэлжээ. Түрүүлж төрсөн хүү нь улаан арьстай үсэрхэг байсанд "Есав" гэдэг нэр өгөв. Дараагийн хүү нь ахынхаа өсгийнөөс зуурч гарсан тул "Иаков" гэж нэрлэжээ. Тэд ихэр боловч хоорондоо огт өөр байв.

Зарц Есав нь хүчтэй том биетэй болохоор гүйж харайх дуртай нэгэн байв. Тэр өсөж том болоод зоригтой анчин болжээ. Эцэг Исаак нь Есав хүүдээ маш хайртай байв. Харин Иаков нь хонь малаа хариулан, гэрийн ажилд тусалдаг нэгэн байв. Эх Ребека нь Иаков хүүдээ илүү хайртай байлаа.

Аав

Тайлбарлагч Нэгэн өдөр, Иаков шөл хийж байлаа. Өдөржин ан хийж байгаад ирсэн Есав ихэд өлссөн байв.

Есав "Иаков! Шөлнөөсөө жаахан өгөөч?."

Иаков "Тэгвэл та ууган хүүгийн эрхээ надад өг. Тэгвэл би шөлнөөсөө өгье."

Есав "Ууган хүүгийн эрхээ?? Тэг, тэг чи ав. Би хариугүй өлсөж үхэх гэж байхад юун ах байх эрх манатай"

Тайлбарлагч Ингэж Есав ууган хүү байх эрхээ чухал гэж бодолгүй, дүүгийнхээ хэлснээр хийв.

Тайлбарлагч Цаг хугацаа өнгөрсөөр, Исаак өвгөрөн хөгширчээ. Түүний хоёр нүд нь муудан сайн харж чадахгүй байлаа. Нэгэн өдөр, Исаак том хүү Есаваа дуудав.

Исаак "Есав хүү минь, чи миний төлөө ан хийж, өөрийнхөө дуртай хоолыг хийн надад авчирч өгөөч. Тэгээд би чамайг ерөөе.

Есав "Нээрээ юу? Тэгвэл би хурдан яваад ирье."

Тайлбарлагч Есав баяртайгаар анд гарчээ.

Тайлбарлагч Гэтэл, эцэг хүү хоёрын яриаг Ребека сонсоод түүнд нэгэн бодол төржээ. Ребека Иаковтоо илүү хайртай байсан тул энэ бүхнийг түүгээр хийлгэхийг хүсчээ.

Ребека "Иаков хүү минь, ахаасаа өмнө тэр ерөөлийг авчихвал сайн даа"

Тайлбарлагч Ребека Иаковыг дуудаад ингэж хэлэв.

Ребека "Иаков, миний хүү хамгийн сайнаас нь шилж байгаад нэг ишиг аваад ир. Чи тэр ивээлийг авбал зохино."

Иаков "Ээж, ах их үсэрхэг шүү дээ. Би үсгүй учир аав намайг тэмтэрч үзээд л мэдчихнэ."

Ребека "Юунд санаа зовно вэ? Танигдахгүй байх арга байгаа."

Тайлбарлагч Ребека, Иаковын авчирсан ишигээр Исаакийн дуртай хоолыг хийжээ. Тэгээд Есавын хувцаснаас Иаковт өмсүүлэв. Мөн Иаковын гар, хөл, хүзүүнд нь ямааны үс наачихжээ



62 Page



63 Page

-
- Тайлбарлагч** Иаков ээжийнхээ хийсэн хоолыг барьсаар аав дээрээ очив.
- Иаков** "Аваа!"
- Исаак** "Хэн бэ?"
- Иаков** "Би Есав байна. Та өндийн хоол идэж, надад ерөөлөө хайрлааач."
- Тайлбарлагч** Иаков баригдвал яанаа гэж сандарч, зүрх нь хүчтэй дэлсэж байлаа.
- Исаак** "Нааш ир, хүү минь. Есав мөн эсэхийг шалгая."
- Тайлбарлагч** Исаак Иаковт хүрч үзэв.
- Исаак** "Хоолой чинь Иаковынх шиг хирнээ гар чинь Есавынх шиг байна. Би андуурчээ"
- Тайлбарлагч** Хөгширч, хараа нь муудсан Исаак Иаковын үс наасан гар хөлийг нь барьж үзээд Есав мөн байна гэж итгэв. Тэгээд хоолоо идээд, Иаковыг ерөөжээ.
- Хэсэг хугацааны дараа Есав ангаас ирж, хоол хийгээд аав дээрээ очив.
-
- Тайлбарлагч** Хэсэг хугацааны дараа Есав ангаас ирж, хоол хийгээд аав дээрээ очив.
- Исаак** "Чи хэн бэ?"
- Есав** "Аав аа, би таны хүү Есав байна"
- Исаак** "Юу гэнээ? Түрүүхэн би чамайг ерөөсөн шүү дээ."
- Тайлбарлагч** Есав маш их уурлан, хашхирав.
- Есав** "Авааа Иаков намайг ингэж хоёр удаа хуурлаа. Өмнө нь миний ууган хүү байх эрхийг авсан бол харин одоо миний ерөөлийг авчихлаа. Гэсэн ч та намайг ерөөж өгөөч"
- Исаак** "Би аль хэдийн бүх зүйлээрээ түүнийг ерөөсөн, одоо дахин чамайг яаж ерөөх билээ?"
- Тайлбарлагч** Есав, гунигтайгаар чангаар ихэр татан уйлав. Тэр дүү Иаковаа маш ихээр үзэн ядаж байлаа.
- Есав** "Аавыг өнгөрсний дараа би Иаковыг заавал алах болно доо."
- Тайлбарлагч** Есавын үгийг эх Ребека нь нууцаар сонсчихов. Тэгээд Иаковыг үхүүлэхгүйн тулд ах Лабаных уруу зугтаалгажээ.